



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 35

Сангийн далай

**Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх
зардлын нэгж тариф батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “д”, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан “Аргачлал батлах тухай” 2018 оны 192,А/243 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан нэгж тарифийг үндэслэн хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураамжийг өрх, албан байгууллагаас бүрдүүлэх ажлыг чанартай зохион байгуулж орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Байгаль орчны улсын байцаагч, татварын улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Н.НУЛУУН



Эрдэнэдалай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 35 дугаар тогтоолын хавсралт



Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамжийн хэмжээ

| № | Хог хаягдлын нормативын ангилал | | Хэмжих нэгж | Нэгжээс авах хураамжийн хэмжээ/төгрөгөөр/ |
|----|--|--|---------------------------------|---|
| 1 | Айл өрх | Гэр хороолол | 1 өрх | Сард 3500 |
| | | Орон сууц, амины орон сууц /Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон/ | 1 өрх | Сард 2500 |
| | | Тус сумын нийт өрх | 1 өрх | Жилд 7000 |
| 2 | | | | |
| 3 | | | | |
| 4 | Зочид буудал, амралтын газар, жуулчны бааз | | Жилд | 100,000 |
| 5 | Хүүхдийн цэцэрлэг, ясли | | Жилд | 50,000 |
| 6 | Ерөнхий боловсролын сургууль, | | Жилд | 50,000 |
| 7 | Албан байгууллага, банк | | Жилд | 50,000 |
| 8 | Соёлын төв | | Жилд | 50,000 |
| 9 | Эрүүл мэндийн байгууллага | | Жилд | 50,000 |
| 10 | Уурын зуух | | Жилд | 150,000 |
| 11 | Мал нядалгааны газар | | 1 мал | 500 |
| 12 | Худалдаа, үйлчилгээ | Эмийн сан | Жилд | 30,000 |
| 13 | | Худалдааны төв, Хүнсний дэлгүүр, супер маркет | Жилд | 50,000 |
| 14 | | ШТС | Жилд | 100,000 |
| 15 | | Авто засвар, дугуй засвар | Жилд | 30,000 |
| 16 | | Үсчин, салон, гоо сайхан, оёдол, халуун ус, | Жилд | 30,000 |
| 17 | | Ресторан, бар, кафе, цайны газар | Жилд | 100,000 |
| 18 | Барилгын хог хаягдал | | м2 | 2000 |
| 19 | Уул уурхайн хог хаягдал | | Үйл ажиллагаа явуулж байгаа үед | 148000 |
| 20 | Фермерийн аж ахуй /тэжээвэр амьтан/ | Гахай | 1 гахай /жилд / | 1000 |
| 21 | | Тахиа | 1 тахиа /жилд / | 800 |